

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАР ДАХЬ МОНГОЛ УЛС, ОХУ-ЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*А.Нямдолжин**

Монгол Улсын боловсрол нь нийгэм-түүхэн нөхцлийнхөө дагуу хөгжлийн тодорхой үе шатуудыг туулан шинэчлэн өөрчлөгдсөөр байна. Монгол Улс 1921-1990 он хүртэлх 70 орчим жилд социалист нийгмийн боловсролын тогтолцоог үүсгэн төлөвшүүлж, орчин үеийн олон шинжлэх ухааны агуулга, арга зүй бүхий боловсролыг иргэддээ эзэмшүүлж байсан бол 1990 оноос хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм, зах зээлийн харилцаанд нийцүүлэн боловсролын тогтолцоогоо ч, боловсролын агуулга, арга зүйгээ ч шинэчилсээр ирлээ.

Монгол Улсын Засгийн газраас 2006-2015 онд хөгжүүлэх боловсролын хөгжлийн урт хугацааны тогтвортой хөгжлийн төлөвлөгөөг баталсан нь 2000 онд дэлхийн дээд хэмжээний уулзалтаар баталсан “Мянганы хөгжлийн зорилтууд”, 2000 оны дэлхийн форумар баталсан “Бүх нийтийн боловсролын Дакарын үйл ажиллагааны хүрээ”, НҮБ-аас 2003 онд баталсан “Тогтвортой хөгжлийн төлөө боловсрол-НҮБ-ын арван жил”, “Бичиг үсгийн боловсролын НҮБ-ын арван жил” гэх мэт хүний хөгжил, боловсролын талаарх дэлхий дахины зорилт, хүчин чармайлтуудыг хэрэгжүүлэхэд Монгол Улс хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар биелүүлж буйн бас нэг нотолгоо юм. Дээд боловсрол нь эдийн засгийн өрсөлдөх чадварыг тодорхойлох, улмаар улсын Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх гол хөдөлгүүр болж байна. Эдүгээ хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн хувьсгалд тулгуурлан аж үйлдвэржсэн нийгмээс мэдээлэлжсэн нийгэм рүү шилжиж байгаатай уялдан дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага нь мэдээлэлжсэн нийгмээс гаралтай мэдлэгт суурилсан эдийн засаг дэлхий дахинд даяаршиж байгаагаар тодорхойлогдож байна. Дэлхийн зах зээлд аливаа улс нэвтрэхэд өндөр технологи, шинжлэх ухааны ололт тэргүүлэх үүрэгтэй болсон өнөөгийн нөхцөлд манай орны хувьд дэлхийн эдийн засаг, зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, хөгжлийг тодорхойлогч “тулгуур цэгийн” үүргийг биелүүлж чадахуйц мэргэжилтэй боловсон хүчинтэй болох явдал чухал юм.

Мэдлэгт суурилсан эдийн засгийн нөхцөлд шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлж инноваци хийхэд хөдөлгөх хүч болсон өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх гол уурхай нь их сургууль юм. Иймээс ч хөгжилтэй орнуудад бизнесийн компаниуд хөрөнгө оруулалтынхаа 1/3 хувийг мэдлэгт суурилсан интанжибл капитал бүтээхэд зориулж байна. Дээд боловсролын хувьд хамгийн хүчтэй экспортлогч нь АНУ, Англи, ХБНГУ, Канад, Австрали байна. Энэ

* А.Нямдолжин - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

чиглэлээр идэвхитэй ажиллаж байгаа орны тоонд ОХУ, Шинэ Зеланд, БНСУ орж байна.

Дэлхий дахинд өндөр нэр хүндтэй Оросын боловсролын тогтолцоог хоёр талын хамтын ажиллагааны хүрээнд ашиглах явдал Монгол, Оросын боловсролын салбарын хамтын ажиллагааг өндөр үр ашигтай болгож байгаа юм.

Хоёр орны ард түмний хоорондын оюун санааны болон соёлын ойр дотно уламжлалт хэлхээ холбоо нь өнөөгийн ардчилсан шинэчлэлтийн үеийн харилцан итгэлцэл, харилцан шүтэлцээт түншлэл, адил тэгш байх түгээмэл зарчим дээр тулгуурлан хөгжиж байна. 1990-ээд онд Монгол Улсад гарсан нийгэм-эдийн засаг, улс төрийн болон ардчилсан өөрчлөлт, ЗХУ-ын задрал нь хоёр орны хамтын ажиллагааны хэлбэр, агуулгыг өөрчилж, харилцааг цоо шинэ түвшинд гаргах шаардлагыг нөхцөлдүүлсэн юм.

Энэ үеэс эхлэн өнгөрсөн үеийн харилцаанд дүн шинжилгээ хийж, шинэ орчин нөхцөлд үүсэж буй харилцааны эрх зүйн үндсийг шинэчлэх шаардлага гарч ирлээ. 1990 оноос хойш хоёр орон зах зээлийн харилцаанд шилжих үйл явцтай уялдан хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд гарсан өөрчлөлтийн үр дүнд ялангуяа боловсрол, соёл, хүмүүнлэгийн салбар дахь хамтын ажиллагаа зогсонги байдалд орсон хэдий ч өнөөдөр хоёр орны харилцааны эрх зүйн үндэс шинэчлэгдээд байна.

1993 оны 1 дүгээр сарын 20-нд байгуулсан Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Гэрээ нь өнөөгийн харилцааны эрх зүйн шинэ үндэс болсон бөгөөд тус Гэрээнд тусгасан зарчмуудыг хоёр талын сайн хөршийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд мөрдлөг болгож байна. Энэхүү гэрээний дагуу 1994 оноос ОХУ өөрийн хөрөнгөөр монголын 20 оюутан, 5 аспирантыг сургаж эхэлжээ. ОХУ-ын их, дээд сургуулиудад тэтгэлэгтэй сургах монгол оюутнуудын тоог оросын тал жилээс жилд нэмэгдүүлж байгаа бөгөөд 1996-1997 оны хичээлийн жилд 60 оюутан, 30, 1999-2000 оны хичээлийн жилд 130, 2000-2001 оны хичээлийн жилд 150, 2004-2005 оны хичээлийн жилд 200-д хүрээд байна. 2008-2009 оны хичээлийн жилд ОХУ-ын Засгийн газраас 220 монгол иргэнийг их дээд сургуульд суралцуулахаар шийдвэрлэсэн. 2009 оны 1 дүгээр сарын байдлаар ОХУ-ын 26 хотын 109 их дээд сургуульд 1500 орчим хүн сурч байгаагаас Засгийн газар хоорондын гэрээний дагуу 778, хувийн болон байгууллагын зардлаар 720 орчим иргэн сурч байна.

Сүүлийн үед ОХУ-аас Монголд суралцагсдын тоог өсгөсөн төдийгүй, гадаадын оюутнуудын амьдрах нийгмийн нөхцөл, аюулгүй байдлын асуудалд анхаарч байна.

1995 оны 4-р сарын 5-нд Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын засгийн газар хоорондын боловсрол, соёл, шинжлэх ухааны хамтын

ажиллагааны тухай хэлэлцээр нь энэхүү салбарын хамтын ажиллагааны эрх зүйн үндэс болж, хүмүүнлэгийн салбарт, түүний дотор Монголын боловсон хүчнийг ОХУ-ын их, дээд сургуулиудад сургах, мэргэжилтнүүдийг бэлтгэх, давтан сургах, сургалтын программ солилцох, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн зүтгэлтнүүдийн хоорондын харилцаа холбоог хөгжүүлэх хүрээнд хамтран ажиллаж байна.

2003 онд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд Соёл, шинжлэх ухаан, боловсролын салбарт 2003-2006 онд хамтран ажиллах тухай хөтөлбөр, 2006 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр орны цаашдын хамтын ажиллагааг тодорхойлсон хэд хэдэн баримт бичигт гарын үсэг зурсаны дотор ОХУ-ын соёл, киноматографийн агентлаг, Монгол Улсын боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөр, 2008 оны 4-р сард Монгол Улсын Ерөнхий Сайд С.Баяр ОХУ-д айлчлах үеэр 2008-2011 онд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх хөтөлбөр, Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярын 2009 оны 3-р сард ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд 2009-2011 онд боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах гэрээнд тус тус гарын үсэг зурж, нийт тэтгэлгээр суралцагчдын тоо 230 болоод байна.

ОХУ-ын ерөнхийлөгч Д.А.Медведев 2009 оны 8 дугаар сарын 25-нд Монгол улсад айлчлах үеэр Монгол Улс, Оросын Холбооны Улс нь хүмүүнлэгийн салбарт, түүний дотор багш, шинжлэх ухааны ажилтан, аспирант, дадлагажигчид солилцох, хоёр орны их дээд сургуулиудад суралцах тэтгэлэг олгох, эрдэм шинжилгээний ажлыг хамтран хийх зэрэг чиглэлээр цаашид хамтран ажиллахын зэрэгцээ монголын иргэдийг оросын сургуулиудад элсүүлэх тоо хэмжээг цаашид нэмэгдүүлэх асуудлыг авч үзэхээр тохиролцсон байна.

Бүс нутгийн болон хил орчмын нутгийн түвшинд хоёр орны боловсролын салбарын хөтөлбөрийн арга хэмжээнүүд амжилттай хэрэгжиж байгаа нь олон зууны турш нүүдлийн соёл иргэншлийг хамтдаа бүтээсэн угсаа гарал, хэл, соёл, ёс заншил, амьдрал ахуй ойролцоо ард түмнүүд зэрэгцэн оршиж үнэт зүйлээ хуваалцаж байдаг сайхан уламжлалаас үүдэлтэй юм.

1990 оны эхнээс Монгол, Оросын харилцаа хуучин тогтолцооны задралын давалгаанд өртөн ерөнхийдөө үлэмж суларч саарсан хэдий ч, бүс нутаг, субъектуудын уламжлалт шууд харилцааг хадгалж сэргээн хөгжүүлэх эрмэлзэл, чармайлт тасалдаагүй билээ.

Монгол Улс, ОХУ-ын их, дээд сургуулиудын хоорондын хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байгаагийн дээр манай улсад Оросын их, дээд

сургуулиудын салбарууд байгуулагдан ажиллаж эхэлсэн нь хамтын ажиллагааны түүхэн дэх шинэ хэлбэр юм. Өнөөгийн байдлаар Улаанбаатарт Москвагийн Эрчим хүчний их сургууль, Багшийн их сургууль, Плехановын нэрэмжит Эдийн засгийн Академи, Эрхүүгийн техникийн их сургуулийн салбар, Дорнод Сибирийн Хүнсний технологийн дээд сургууль, Буриад, Кемеровын улсын их сургуулиудын салбарууд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд манай нийслэл, бусад хот суурин газруудад цөөнгүй тоогоор байгуулагдсан орос хэл дээр сургалттай бага, дунд сургууль, цэцэрлэгүүдийн хамт манай боловсролын тогтолцоонд байр сууриа эзэлжээ.

Монгол, Оросын олон талын хамтын ажиллагааны нэг талбар бол шинжлэх ухааны салбар юм. Шинжлэх ухааны салбар дахь хоёр орны хамтын ажиллагаа нь манай улсад эрдэм шинжилгээний боловсон хүчин бэлтгэх, шинжилгээ, судалгааны байгууллагуудыг зохион байгуулах зэргээр тасралтгүй хөгжиж ирсэн баялаг түүхтэй.

Өнөөгийн ардчилал, нийгмийн дэвшил, шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй хөгжил, мэдээллийн эрин зууны үед шинэ мэдлэг түгээх, мэдлэгээс бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологи бий болгох замаар нийгмийн хөгжлийг хангахад шинжлэх ухааны үүрэг эрс өсч байна.

1998 онд Улсын Их Хурлаар баталсан “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоол зэрэгт Монгол Улсын Шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхээр заасны дагуу Монгол Улсын Засгийн газраас 2007 онд Монгол Улсын Шинжлэх ухаан технологийг 2007-2020 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг батлан гаргасан байна. Дэлхий нийтийн мэдээллийн технологийн түргэн хөгжил даяаршлын эрчимтэй нөлөөлөл, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт зэрэг хүчин зүйлс нь Мастер төлөвлөгөө хэрэгжүүлэх хам нөхцөл болж байна.

ОХУ суурь судалгааны өндөр чадамжтай орны хувьд “ОХУ-ын шинжлэх ухаан, инновацийг 2015 он хүртэл хөгжүүлэх стратегийг” боловсруулан хэрэгжүүлж байгаа билээ. Өнөөгийн байдлаар Монгол Улсын ШУА ОХУ-ын ШУА-ийн 30 гаруй хүрээлэн төв, их сургуулиудтай экологи, газар зүй, цэвдэг судлал, одон орон, ургамал, амьтан судлал болон эрдэмтэн судлаач бэлтгэх чиглэлүүдээр хамтран ажиллаж байна. Эрдэм шинжилгээний хэлхээ холбоо нь орос-монголын хамтын ажиллагааны зонхилох бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг юм.

Манай хоёр орны хөгжлийн чанарын шинэ дэвшлийг авчирсан он жилүүд нэгэнт эхэлж төрийн тэргүүнүүд энэ харилцаанд онцгой үүрэг гүйцэтгэж байна.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2000 онд Монгол Улсад, 2006 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр ОХУ-д албан ёсны айлчлал хийв.

Уг айлчлалуудын хүрээнд хоёр улсын төрийн тэргүүн нар Монгол, Оросын харилцааг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх асуудлыг хэлэлцэж, олон талын асуудлаар санал солилцож, Улаанбаатар болон Москвагийн тунхаглалд гарын үсэг зурсан. Москвагийн тунхаглалд “Хоёр орны ард түмний оюун санааны болон соёлын ойр дотно уламжлалт хэлхээ холбоог хадгалан бэхжүүлэхийн төлөө байдаг. Монгол Улс, ОХУ нь ОХУ-ын их, дээд сургуульд суралцаж байгаа монгол оюутны тоог нэмэх, мэргэжилтэн бэлтгэх, давтан бэлтгэх, сургалтын хөтөлбөр солилцох замаар хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах болно. Монгол Улсад орос хэлийг, Орос улсад монгол хэлийг сурах, судлахыг хөхиүтэн дэмжих болно” хэмээн тунхаглажээ.

Дэлхийн хэмжээний шинжтэй болсон Монгол судлалын хөгжилд Монгол, Оросын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн гүйцэтгэж ирсэн үүрэг, хамтын чармайлтын ач холбогдлыг олон улсын монголч эрдэмтдийн их хурлууд, монголчуудын нүүдлийн соёл иргэншлийн асуудлаар тогтмол зохиогддог эрдэм-шинжилгээний хурал, симпозиумууд, Монголын шинжлэх ухааны байгууллагууд ба ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн хооронд өргөжин хөгжиж буй хамтын ажиллагаа, хамтарсан судалгаа, хамтын бүтээлүүд бэлхнээ харуулж байгаа билээ.

Манай хоёр орны хувьд бизнес-шинжлэх ухааны хосолсон бүтэц, харилцан уялдсан үйл ажиллагаа дутмаг юм. ОХУ-д хэрэгжүүлж буй сансар судлал, иргэний агаарын хөгжил, үндэсний технологийн бааз зэрэг хөтөлбөрийн хүрээнд манай улсын шинжлэх ухаан технологийн салбарт хамтран ажиллах боломжууд бий. ОХУ суурь судалгааны сан, хүмүүнлэгийн ухааны сан, шинжлэх ухаан, технологийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийг дэмжих сантай хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлснээр мэдээлэл, харилцаа холбоо, био технологи, нанотехнологийг хөгжүүлэх, өндөр, дунд технологи бүхий үйлдвэрлэл, үйлчилгээг өргөтгөхөд бодитой хувь нэмэр оруулах юм.

Монгол, Оросын Засгийн Газрын хоорондын соёлын хөтөлбөрийн үндсэн дээр олон төрөл шат хэлбэр бүхий соёлын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Монгол, Оросын хоорондын ард түмнүүдийн хэлхээ холбоо нь олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, залуучуудын солилцоо, соёлын өдрүүдийг харилцан зохион байгуулах, урлагийн наадам, айлчлан тоглолт болон бусад соёлын арга хэмжээнүүд идэвхижиж байна.

1995 оны 4 дүгээр сард Монгол Улсын Ерөнхий сайд. П.Жасрай ОХУ-ын Засгийн Газрын дарга В.Черномырдины урилгаар Москвад айлчлан хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны талаар өргөн хүрээтэй хэлэлцээр хийж, олон чухал баримт бичигт гарын үсэг зурсан байна. Үүнд: Шинжлэх ухаан ба соёлын яамны ажиллагааны тухай, иргэд харилцан зорчих тухай, шуудан цахилгаан холбооны салбарт хамтран ажиллах тухай, ус, цаг уурын ба байгаль орчны

хамгаалалтын салбарын хамтын ажиллагааны Протокол зэрэг арваад баримт бичиг орсон юм. Мөн онд ОХУ-ын Засгийн газрын дэд тэргүүн О.Давыдов Монголд айлчилж, Ерөнхий сайд П.Жасрайн Москвад айлчлах үеэр тохирсон асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд хэлэлцээрүүдийг хийжээ.

Монгол Улстай шууд хил залгаа оршиж буй бус нутаг, субъектуудын хамтын ажиллагаа богино хугацаанд нийгмийн амьдралын олон хүрээг хамарч өргөжин, түүнд соёл, хүмүүнлэгийн болон эдийн засгийн чиглэл давамгайлахын хамт, хамтын ажиллагааны механизм, эрх зүйн үндэс бүрэлдэн бодитой үр дүнд хүрч байна.

Монгол, Оросын хил залгаа орших ард түмнүүд хамтын ажиллагааны баялаг уламжлалаа сэргээн соёл иргэншил, хэл, заншил, нийтлэг сонирхлын үнэт зүйлээ хөгжлийн хүчин зүйл болгосноор эрчтэй хурдтай хөгжих таатай нөхцөл бүрэлдүүлж байна.

Бүс нутаг, хил орчим, субъект хоорондын хамтын ажиллагаа зөвхөн хоёр талын үндсэн дээр төдийгүй, хэд хэдэн бүс нутаг, субъект хооронд олон талын үндсэн дээр хөгжих өргөн боломжтой юм. Бүс нутаг, субъектуудын олон талын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд баялаг уламжлалтай бөгөөд нөөц чадавхи ихтэй салбарт юуны өмнө соёл урлаг, спорт, аялал жуулчлалыг нэрлэж болно. Монгол, Оросын хилийн шугамын дагуу гарал үүсэл, хэл соёл, зан заншлын салшгүй холбоотой ард түмнүүд оршин амьдарч ирсэн түүхэн уламжлал, харилцан хамаарал, нийтлэг сонирхол, эрх ашиг нь эдүгээ ч тэдгээр ард түмний олон талын хамтын ажиллагааг идэвхжүүлж буй чухал хүчин зүйл болж байна.

Дүгнэлт

Эрин үед дэлхий нийтийн хэмжээнд даяаршлын үйл явц түргэсч, улс үндэстнүүд хоорондын хэлхээ холбоо өдөр ирэх тусам өргөжин тэлж, солилцоо, хамтын ажиллагаа идэвхжин, энх тайван, хамтын хөгжил нь улс үндэстнүүдийн нийтлэг үзэл баримтлал, хамтын зорилт болж байна. Тэр тусмаа хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан техник, боловсролын салбар дахь харилцаагаа юуны өмнө түлхүү хөгжүүлж эрчимжүүлэх нь шинэ зууны хамтын хөгжлийн нэг онцлог юм. Монгол, Оросын боловсролын салбар дахь хамтын ажиллагаа нь бүх талын өргөн түншлэл, оролцоотойгоор боловсролын тогтвортой хөгжлийг дэмжиж орж ирэх хөрөнгө оруулалт, дэмжлэг туслалцааг нэмэгдүүлэх зарчимд тулгуурлан хөгжиж байна. Өндөр чадвартай боловсон хүчин бэлтгэхэд энэ талын харилцааны уламжлал дээр түшиглэн ОХУ-тай нягт хамтран ажиллах нь Монгол Улсын хөгжлийн стратегийн нэг чухал чиглэл байх болно.

Хоёр орны боловсролын салбар дахь хамтын ажиллагааг цаашид улам гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд анхаарвал зохилтой асуудал байгааг дурдах нь

зүйтэй гэж бодож байна. Монгол Улс, ОХУ-ын Боловсролын яам, Гадаад хэргийн яамд хийгээд хоёр орны Засгийн Газрын түвшинд яригдаггүй нэг асуудал бол ОХУ-д сурахаар явж байгаа оюутан, залуучуудын амь настай холбоотой аюулгүй байдлын асуудал юм. ЗХУ задарсаны дараа бий болсон улс төр, эдийн засгийн хүнд байдлаа орос биш үндэстнүүдтэй холбон тайлбарладаг хүчин гарч ирсэн нь Их Оросын үзэлт нацист бүлэглэл болох халзан толгойнууд буюу скинхэдүүд юм. Өнөөдөр ОХУ-ын хэвлэл мэдээллийн бүхий л хэрэгслээр арав, хориулаа сүрэлгэн явдаг 14-16 насны скинхэдүүдийн халдлагад өртөн амь насаа алдаж байгаа орос биш төрхтэй гадаадын болон дотоодын оюутан залуучуудын тухай мэдээ тасардаггүй бөгөөд оросын их, дээд сургуулиуд гадаад оюутнууддаа Гитлерийн болон Лениний төрсөн өдөр хичээлдээ ирэхгүй байхыг зөвшөөрдөг, гадуур ганц хоёроороо явахгүй байхыг албан ёсоор мэдэгддэг болжээ. Иймд ОХУ-д сурахаар явж байгаа оюутан залуучуудын амь настай шууд холбоотой энэ асуудлыг ОХУ-ын талд албан ёсоор тавьж, иргэдийнхээ аюулгүй байдлыг хамгаалуулах талаар анхаарлаа хандуулах цаг болсон гэж үзэж байна.

ОХУ-д тэтгэлгээр сурч байгаа монгол оюутанд сард 900 рубль, аспирантад 1750 рублийн стипенди олгодог нь маш бага мөнгө бөгөөд ОХУ-д сурах тэтгэлэг гэдэгт зөвхөн сургалтын төлбөр ордог бөгөөд замын зардал, байр, хоол, унаа, эрүүл мэндийн даатгал, виз, регистраци, эрүүл мэндийн шинжилгээ гэх мэт бусад зардлуудыг хувиараа төлдөг учир Япон, Солонгос зэрэг бусад орнуудад тэтгэлгээр сурахад сургалтын төлбөрөөс гадна бусад бүх зардлууд тэтгэлэгт багтахын зэрэгцээ сард 500 орчим долларын стипенди олгодог нь эдгээр орнуудад сурах сонирхол монголын залуучуудын дунд илүү байна. Монголын Засгийн газраас ОХУ-д сурах оюутны квотыг нэмэгдүүлэх тал дээр санал тавидаг боловч оюутны аюулгүй байдал, амьжиргааны асуудлуудыг дурдахгүй өнгөрөөдөг. ОХУ-д улсад сурч байгаа оюутнуудтайгаа ОХУ дахь Монгол Улсын Элчин Сайдын Яам нь харилцаа холбоо муутай ажилладаг, Москва, Улаан-Үүд, Эрхүү хотуудаас бусад том хотуудад Консулын газар байхгүй зэрэг нь өөрийн орны иргэдийн төлөө тавих анхаарал дутмаг байгаа нь ажиглагдаж байна.

Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд өндөр технологи ба шинжлэх ухааны багтаамж ихтэй салбар манлайлах үүрэг гүйцэтгэх болсон өнөөгийн нөхцөлд шинжлэх ухаан, технологи, уул уурхай, уран, нефть боловсруулах чиглэлээр ОХУ-д суралцагчдын тоог нэмэгдүүлэх, ялангуяа энэ чиглэлийн эрдэм шинжилгээний байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, шинжлэх ухааны судалгаа, туршилт, зохион бүтээх ажлыг хамтран гүйцэтгэх, наноматериал судлалын хөтөлбөр хэрэгжүүлэн, судалгааны үр дүнг үйлдвэрт нэтрүүлэхэд хамтран ажиллах асуудлыг хоёр орны засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөрт тусгах нь хөгжлийн дараагийн үе шатыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

Монгол, Оросын найрсаг харилцаа, хамтын ойлголцлыг гүнзгийрүүлэн бэхжүүлэхэд соёлын солилцоо нь ард түмнүүдийн хоорондын хамтын ажиллагаа болон тэдний соёл, оюуны үйл ажиллагаа, аж амьдралын хэв маягийг ойлгоход тус дөхөм болж байдаг. Иймд энэ салбар дахь харилцаа хамтын ажиллагааг улам өргөжүүлэн хөгжүүлэх чиг шугамыг цаашид тууштай баримталж, түүний бодит үр өгөөжийг улам сайжруулахад түлхүү анхаарах нь чухал юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө. Улаанбаатар, 2007.
2. Монгол Улсын шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө. Улаанбаатар, 2006.
3. Монгол, Орос, Хятад: XXI зуунд хөгжлийн төлөө хамтдаа. Улаанбаатар, 2009.
4. Монгол-Оросын харилцаа. Бүсчилсэн хөгжлийн бодлого, хамтын ажиллагаа. Улаанбаатар. 2005.
5. Монгол Улсын хөгжлийн судалгаа. Улаанбаатар. 2007.
6. “Олон улс судлал” сэтгүүл. 2007. №3
7. М.Б.Мешанинов. Регионы России в торгово-экономическом сотрудничестве с Монголией. М. 2008.
8. Владимирцовские чтения V. Доклады Всероссийской научной конференции (Москва. 16 ноября 2005 г.)
9. Боловсролын баримт бичиг, эрдмийн зэрэг, эрдмийн цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Москва. 2003 оны 7-р сарын 1.
10. Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого. МУ-ын Их Хурлын 1998 оны 55 дугаар тогтоолын хавсралт. 1998.05.14
11. Новости Монголии, 1 марта 2004 года. №09 (440)
12. МОНЦАМЭ. 2008-4-14.
13. Дипломатический вестник. 2003.№8
14. Стратегия развития науки и инноваций в Российской Федерации на период до 2015 года.
<http://www.youngscience.ru/753/820/979/index.shtml>
15. Протокол о сотрудничестве между Верховным Советом Калмыцкой Советской Социалистической республики и Бага Хуралом Монгольской Народной Республики на 1991-1992 гг. // Советская Калмыкия. 30.04.1991
16. Программа развития nanoиндустрии в Российской Федерации до 2015 года. Москва. 2008.
17. Вестник центра “Москва-Улаанбаатар”. 2008. №6-7.